



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/186-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)  
Сүхбаатар сум  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)  
Аудитыг гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК  
Захирал: Х.Ариунзул  
Утас: 99077062 Цахим хаяг: [ikhnayadaudit@gmail.com](mailto:ikhnayadaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>1. АУДИТЫН ДҮГНЭЛТ</b>	<b>2</b>
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b>	<b>4</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b>	<b>10</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b>	<b>14</b>
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b>	<b>17</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b>	<b>18</b>

### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БЕГ</b>	Боловсролын ерөнхий газар
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>НБББББ</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>МУЕА</b>	Монгол улсын ерөнхий аудитор
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР  
СУМЫН ДУЛААНХААН ТОСГОНЫ  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.ДЭЛГЭРЦЭЦЭГ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/186/НЯ-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж, урамшуулалд 24,630.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Тус сургуулийн мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох

018020230

бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа боловсролын байгууллагын онцлогт тохирохгүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 84.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Сэлэнгэ аймгийн засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн захирамжаар Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд “дүйцсэн хөтөлбөрийн сургалт” явуулах эрхийг нэмж, нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>236,454,005.82</b>	<b>272,078,242.07</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	124,142,942.22	156,268,531.96
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	124,142,942.22	156,268,531.96
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	124,142,942.22	156,268,531.96
31211	Төрийн сангийн харилцах	124,142,942.22	156,268,531.96
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	450,000.00	6.89
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	6.89
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	450,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	450,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	111,861,063.60	115,809,703.22
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	111,861,063.60	115,809,703.22
35410	Бичиг хэргийн материал	12,275,394.65	167,000.00
35420	Аж ахуйн материал	38,127,099.44	30,182,675.00
35450	Барилгын засварын материал	19,082,300.00	19,082,300.00
35460	Хүнсний материал	-	1,084,170.00
35470	Бусад хангамжийн материал	42,376,269.51	65,293,558.22
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>608,342,884.30</b>	<b>613,089,305.10</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	608,342,884.30	613,089,305.10
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	599,322,484.30	604,068,905.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	624,115,325.77	624,115,325.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(81,081,317.34)	(101,997,480.42)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,500.00)	(14,562,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	120,427,342.26	113,146,619.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	(109,176,901.23)	(90,149,172.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,984,568.18	58,972,218.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,815,861.40)	(31,465,403.02)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	-	(4,384,110.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,046,740.22	25,999,290.22
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,894,024.16)	(8,541,373.92)
39217	Ном	11,716,612.00	18,372,991.50
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	9,020,400.00	9,020,400.00
39301	Программ хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,020,400.00	9,020,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>844,796,890.12</b>	<b>885,167,547.17</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,102,337.46</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,102,337.46</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	<b>1,102,337.46</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,102,337.46
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>844,796,890.12</b>	<b>884,065,201.71</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	844,796,890.12	884,065,201.71

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	319,214,929.37	319,214,929.37
51101	Өмч: - төрийн	319,214,929.37	319,214,929.37
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(21,798,499.43)	17,469,812.16
51210	Өмнөх үеийн үр дүн	(21,798,499.43)	(21,798,499.43)
51220	Тайлант үеийн үр дүн	-	39,268,311.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	547,380,460.18	547,380,460.18
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>844,796,890.12</b>	<b>885,167,547.17</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,602,205,839.27</b>	<b>939,910,213.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>752,556,190.37</b>	<b>39,370,763.26</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>752,556,190.37</b>	<b>39,370,763.26</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	<b>1,895,500.00</b>	<b>4,465,958.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,895,500.00	4,465,958.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	647,167,426.77	16,591,164.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	103,493,263.60	18,313,640.76
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>849,649,648.90</b>	<b>900,539,450.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	771,478,600.00	839,859,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	771,478,600.00	839,859,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	78,171,048.90	60,680,350.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	78,171,048.90	60,680,350.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>757,408,949.15</b>	<b>894,401,458.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>757,408,949.15</b>	<b>894,401,458.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>698,440,399.15</b>	<b>839,634,868.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>494,016,626.10</b>	<b>605,409,717.11</b>
210101	Үндсэн цалин	373,883,865.10	442,999,768.82
210102	Нэмэгдэл	105,855,598.00	138,167,190.29
210104	Урамшуулал	14,277,163.00	24,242,758.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>61,518,515.58</b>	<b>75,477,933.69</b>
210201	Тэтгэврийн даатгал	42,481,265.15	52,647,208.76
210202	Тэтгэмжийн даатгал	4,985,221.04	6,191,847.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,981,456.06	4,850,658.70
210204	Ажилгүйдлийн даатгал	905,103.29	1,057,055.49
210205	Эрүүл мэндийн даатгал	9,165,470.04	10,731,162.80
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,501,600.00</b>	<b>57,857,537.46</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,178,267.31	7,173,684.42
210302	Түлш, халаалт	37,323,332.69	50,333,853.04
210303	Цэвэр, бохир ус	-	350,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>10,279,902.44</b>
210408	Бараа материал акталсны зардал	-	10,279,902.44
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,203,300.00</b>	<b>3,927,150.00</b>

210604	Урсгал засвар	2,203,300.00	3,927,150.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,489,500.00</b>	<b>8,469,022.57</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,895,500.00	2,498,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	594,000.00	5,970,322.57
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>94,710,857.47</b>	<b>78,213,605.28</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,275,815.00	20,106,278.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,383,400.00	9,471,058.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,051,642.47	48,636,268.58
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>58,968,550.00</b>	<b>54,766,590.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>58,968,550.00</b>	<b>54,766,590.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,704,050.00	38,611,290.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,264,500.00	16,155,300.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>844,796,890.12</b>	<b>45,508,754.71</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	6,240,435.12
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	6,240,435.12
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(6,240,435.12)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>844,796,890.12</b>	<b>39,268,319.59</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>851,545,148.90</b>	<b>905,005,408.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,895,500.00</b>	<b>4,465,958.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,895,500.00	4,465,958.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,895,500.00	4,465,958.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,895,500.00	4,465,958.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>849,649,648.90</b>	<b>900,539,450.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	771,478,600.00	839,859,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	771,478,600.00	839,859,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>78,171,048.90</b>	<b>60,680,350.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	78,171,048.90	60,680,350.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>697,175,106.68</b>	<b>834,607,218.26</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>697,175,106.68</b>	<b>834,607,218.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>637,756,556.68</b>	<b>779,218,958.26</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>494,279,108.10</b>	<b>605,409,717.11</b>
210101	Үндсэн цалин	374,007,965.10	442,158,567.87
210102	Нэмэгдэл	105,855,598.00	139,008,391.24
210104	Урамшуулал	14,415,545.00	24,242,758.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>61,256,033.58</b>	<b>75,477,940.58</b>
210201	Тэтгэврийн даатгал	42,142,157.67	52,499,798.56
210202	Тэтгэмжийн даатгал	5,002,589.55	6,168,763.20

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,995,350.09	4,859,424.29
210204	Ажилгүйдлийн даатгал	910,155.91	1,061,758.09
210205	Эрүүл мэндийн даатгал	9,205,780.36	10,888,196.44
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,501,600.00</b>	<b>56,755,200.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,178,267.31	7,173,684.42
210302	Түлш, халаалт	37,323,332.69	49,231,515.58
210303	Цэвэр, бохир ус	-	350,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,445,600.00</b>	<b>3,925,150.00</b>
210604	Урсгал засвар	10,445,600.00	3,925,150.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,494,800.00</b>	<b>8,469,022.57</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,895,500.00	2,498,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,599,300.00	5,970,322.57
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,779,415.00</b>	<b>29,181,928.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,396,015.00	19,710,870.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,383,400.00	9,471,058.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,418,550.00</b>	<b>55,388,260.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>59,418,550.00</b>	<b>55,388,260.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,154,050.00	39,232,960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,264,500.00	16,155,300.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>154,370,042.22</b>	<b>70,398,189.74</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>30,227,100.00</b>	<b>38,272,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,227,100.00</b>	<b>38,272,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>30,227,100.00</b>	<b>38,272,600.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,227,100.00	38,272,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(30,227,100.00)</b>	<b>(38,272,600.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>124,142,942.22</b>	<b>32,125,589.74</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>124,142,942.22</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>156,268,531.96</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны үр дүн
				1
А	1	2	3	4
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,929.37	547,380,460.18	(21,798,499.43)	844,796,890.12
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	319,214,929.37	547,380,460.18	(21,798,499.43)	844,796,890.12
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-		
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,929.37	547,380,460.18	(21,798,499.43)	844,796,890.12
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	319,214,929.37	547,380,460.18	(21,798,499.43)	844,796,890.12
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	39,268,319.59	39,268,319.59
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,929.37	547,380,460.18	17,469,820.16	884,065,209.71

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,033,053,100.00	872,879,818.26	160,173,281.74	84.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,033,053,100.00	872,879,818.26	160,173,281.74	84.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	994,780,500.00	834,607,218.26	160,173,281.74	83.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	735,595,500.00	605,409,717.11	130,185,782.89	82.3
210101	Үндсэн цалин	506,399,600.00	442,158,567.87	64,241,032.13	87.3
210102	Нэмэгдэл	197,263,800.00	139,008,391.24	58,255,408.76	70.5
210104	Урамшуулал	31,932,100.00	24,242,758.00	7,689,342.00	75.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,949,900.00	75,477,940.58	16,471,959.42	82.1
210201	Тэтгэврийн даатгал	62,526,000.00	52,499,798.56	10,026,201.44	84.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,356,000.00	6,168,763.20	1,187,236.80	83.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,884,800.00	4,859,424.29	1,025,375.71	82.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,471,200.00	1,061,758.09	409,441.91	72.2

210205	Эрүүл мэндийн даатгал	14,711,900.00	10,888,196.44	3,823,703.56	74.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>56,755,200.00</b>	<b>56,755,200.00</b>	-	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,921,300.00	7,173,684.42	2,747,615.58	72.3
210302	Түлш, халаалт	46,533,900.00	49,231,515.58	(2,697,615.58)	105.8
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	350,000.00	(50,000.00)	116.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>47,194,900.00</b>	<b>39,232,960.00</b>	<b>7,961,940.00</b>	<b>83.1</b>
210502	Хоол, хүнс	47,194,900.00	39,232,960.00	7,961,940.00	83.1
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,892,600.00</b>	<b>3,925,150.00</b>	<b>1,967,450.00</b>	<b>66.6</b>
210604	Урсгал засвар	5,892,600.00	3,925,150.00	1,967,450.00	66.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,649,500.00</b>	<b>8,469,022.57</b>	<b>2,180,477.43</b>	<b>79.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,435,900.00	2,498,700.00	1,937,200.00	56.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,213,600.00	5,970,322.57	243,277.43	96.1
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,587,600.00</b>	<b>29,181,928.00</b>	<b>1,405,672.00</b>	<b>95.4</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,116,500.00	19,710,870.00	1,405,630.00	93.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,471,100.00	9,471,058.00	42.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,155,300.00</b>	<b>16,155,300.00</b>	-	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,155,300.00</b>	<b>16,155,300.00</b>	-	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,155,300.00	16,155,300.00	-	100.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>38,272,600.00</b>	<b>38,272,600.00</b>	-	<b>100.0</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	38,272,600.00	38,272,600.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,033,053,100.00</b>	<b>905,005,408.00</b>	<b>128,047,692.00</b>	<b>87.6</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>839,859,100.00</b>	<b>839,859,100.00</b>	-	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	839,859,100.00	839,859,100.00	-	100.0
<b>132</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>62,647,800.00</b>	<b>60,680,350.00</b>	<b>1,967,450.00</b>	<b>96.9</b>
132001	Орон нутгийн төсвөөс	62,647,800.00	60,680,350.00	1,967,450.00	96.9
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>6,403,200.00</b>	<b>4,465,958.00</b>	<b>1,937,242.00</b>	<b>69.7</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,435,900.00	4,465,958.00	(30,058.00)	100.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,967,300.00		1,967,300.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	124,143,000.00			-

31	Мөнгө ,түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		124,142,942.22		
31	Мөнгө ,түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		156,268,531.96		

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь "Суралцагч бүрийн сурлагын хоцрогдлыг арилгая" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулах сургах нөхцөлийг бүрдүүлж, сурлагын хоцрогдлыг арилга;
- Хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэн, цахим сан болон даалгаврын санг бүрдүүлж ашиглах;
- Багш бүр сургалтын арга хэлбэр, заах арга зүйгээ оновчтой сонгон заах;
- Багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагааг сайжруулж ажиллах.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд: "ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх"; "Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 885,167.5 мянган төгрөг болж өмнөх оноос 40,370.6 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	124,142.9	156,268.5	32,125.6
Авлага	450.0	-	(450.0)
Бараа материал	111,861.1	115,809.7	3,948.6
Үндсэн хөрөнгө	608,342.9	613,089.3	4,746.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>844,796.9</b>	<b>885,167.5</b>	<b>40,370.6</b>
Өр төлбөр	-	1,102.3	1,102.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	844,796.9	884,065.2	39,268.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>844,796.9</b>	<b>885,167.5</b>	<b>40,370.6</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 156,268.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 115,809.7 мянган төгрөг болж 3,948.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 58,884.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 23,439.7 мянган төгрөгийн материал үнэ төлбөргүй шилжүүлж авсан бөгөөд 78,375.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 613,089.3 мянган төгрөг болж 4,746.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 38,272.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй орлогоор 14,688.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэнтэй холбоотой байна.
- Тайлант онд өр төлбөр дансанд 1,102.3 мянган төгрөгийн өглөг тайлагнагдсан нь халаалтын үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой үүссэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 912,367.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 62,647.8 мянган төгрөг, нийт зарлагыг **975,015.6** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 58,037.5 мянган төгрөгийн орлого эх үүсвэрийг нэмэгдүүлэн тооцож улсын төсвөөс 839,859.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 62,647.8 мянган төгрөгөөр, өөрийн үйл ажиллагаанаас 6,403.2 мянган төгрөг урьд оны дансны үлдэгдлээс 124,143.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн нийт **1,033,053.1** мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 839,859.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 62,647.8 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 124,143.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас 6,403.2 мянган төгрөг, нийт **1,033,053.1** мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **872,879.8** мянган төгрөг буюу **84.5** хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 130,185.8 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 16,471.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,967.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 2,180.5 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 1,405.7 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг зардлыг 7,961.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

		/мянган төгрөгөөр/			
Хөтөлбөр, арга хэмжээ		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>71802 – Ерөнхий боловсрол</b>					
1	Байр ашиглалтын үйлчилгээ	2,485.4	2,485.4	-	100.0
2	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	5,592.2	5,592.2	-	100.0
3	Боловсролын стандарт, сургалт	728,037.0	600,943.6	127,093.4	82.5
4	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	150.7	150.7	0.0	100.0
5	Сурах бичгийн түрээс	4,435.9	2,498.7	1,937.2	56.3
6	Сургалт семинар	1,242.7	1,238.2	4.5	99.6
7	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	147,692.2	126,776.7	20,915.5	85.8
8	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	62,647.8	60,680.4	1,967.5	96.9
9	Үдийн цай хөтөлбөр	47,194.9	39,233.0	7,961.9	83.1
10	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	30,090.3	29,797.6	292.7	99.0
11	Эрүүл мэндийг дэмжих	3,484.0	3,483.4	0.6	100.0
<b>ДҮН</b>		<b>1,033,053.1</b>	<b>872,879.8</b>	<b>160,173.3</b>	<b>84.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хүүхдийн хоол хүнс худалдан авах 47,194.9 мянган төгрөг төсөв батлагдсан байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг [tender.gov.mn](http://tender.gov.mn) цахим сайтад байршуулж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны шалгаруулалтад "Дөлгөөн болор сан" ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Их наяд аудит” ХХК-ийн аудитор Х.Ариунтуяа гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Их наяд аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 757,408.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,574.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээлэл байршуулахаас тус байгууллага нь мэдээллийг цаг хугацаанд нь ил тод, бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

###### **1. Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал**

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 6,565.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг залруулсан.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,204.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс цахим төлбөрийн баримт шивэгдээгүй зөрчилд, тайлант онд авлага үүсгэсэн, шилэн дансны хугацаа хоцроосон мэдээлэлд 3 албан шаардлага, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулга хийж байх зөрчилд 1 зөвлөмж тус тус өгөгдсөн байна.

Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	2,204.6	3	2,204.6	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>2,204.6</b>	<b>4</b>	<b>2,204.6</b>	<b>100.0</b>

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу **1,614.7** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч Г.Алтанзул 905.3 мянган төгрөг,
- Нярав Э.Болор-Эрдэнэд 709.4 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

3. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй болно.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 6,565.9 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас цахим баримтаар баталгаажуулж 6,565.9 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн.

Аудитаар нийт 351.9 мянган төгрөгийн 1 зөрчил илэрч, зөвлөмж өгөв.

### **5.1 Зөвлөмж**

#### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 8 ширхэг үндсэн хөрөнгийн элэгдлийг үлдэх өртгөөс нь илүү байгуулж, хөрөнгийн үлдэх өртгийг 351.9 мянган төгрөгөөр хасах утгаар илэрхийлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.1.Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт; мөн НББОУС-16[6] “Элэгдүүлэх дүн гэдэг нь хөрөнгийн өртөг болон түүнтэй адилтгах дүнгээс үлдэх өртгийг хассан дүн, Үндсэн хөрөнгө дансны үнэ нь үлдэгдэл өртгөөс давж болохгүй.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Бүртгэл тооцоог хянан баталгаажуулан бүртгэл тайланд үнэн зөв тусгаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>1</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг

---

<sup>1</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цахим баримтгүй худалдан авалт гүйцэтгэсэн	1	6,565.9			1	6,565.9	1	6,565.9				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>6,565.9</b>			<b>1</b>	<b>6,565.9</b>	<b>1</b>	<b>6,565.9</b>				

/мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 8 ширхэг үндсэн хөрөнгийн элэгдлийг үлдэх өртгөөс нь илүү байгуулж, хөрөнгийн үлдэх өртгийг хасах утгатай илэрхийлсэн.	1	351.9					1	351.9				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>351.9</b>					<b>1</b>	<b>351.9</b>				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								

/мянган төгрөгөөр/